



МОНГОЛ УЛСЫН  
БОЛОВСРОЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ  
САЙДЫН ТУШААЛ

2023 оны 08 сарын 30 өдөр

Дугаар А/350

Улаанбаатар хот

┌ Сургалтын төлөвлөгөө шинэчлэн ┐  
батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.4 дэх хэсэг, 10 дугаар зүйлийн 10.4 дэх хэсэг, Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2023 оны 08 дугаар сарын 23-ны өдрийн “Хичээлийн жилийн бүтцийг шинэчлэн батлах тухай” А/338 дугаар тушаалыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Ерөнхий боловсролын сургуулийн бага ангийн сургалтын төлөвлөгөөг нэгдүгээр, дунд ангийн сургалтын төлөвлөгөөг хоёрдугаар, ахлах ангийн сургалтын төлөвлөгөөг гуравдугаар хавсралтаар тус тус шинэчлэн баталсугай.

2. Батлагдсан сургалтын төлөвлөгөөг 2023-2024 оны хичээлийн жилээс эхлэн өмчийн бүх хэлбэрийн ерөнхий боловсролын сургуульд мөрдсүгэй.

3. Сургалтын төлөвлөгөөг хэрэгжүүлэх ажлыг нэгдсэн удирдлага, зохион байгуулалтаар хангаж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Ерөнхий боловсролын бодлогын удирдлага, зохицуулалтын газар (Б.Гантулга), Боловсролын ерөнхий газар (Т.Ням-Очир), Нийслэлийн боловсролын газар, аймгийн Боловсрол, шинжлэх ухааны газрын дарга нарт тус тус үүрэг болгосугай.

4. Энэ тушаал гарсантай холбогдуулан Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2019 оны “Сургалтын төлөвлөгөө шинэчлэн батлах тухай” А/491 дүгээр тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

САЙД



Д.ЭНХ-АМГАЛАН

14231 1365

БАГА АНГИЙН СУРГАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Хичээлийн нэр	Хичээлийн цаг (анги тус бүрээр)					Нийт цаг
		I анги	II анги	III анги	IV анги	V анги	
1	Бэлтгэл хөтөлбөр	60					60
2	Монгол хэл	203	224	224	224	224	1099
3	Иргэний ёс зүйн боловсрол	58	64	64	64	64	314
4	Математик	116	160	160	160	160	756
5	Хүн ба орчин	58	64	64			186
6	Хүн ба байгаль				32	64	96
7	Хүн ба нийгэм				64	64	128
8	Дүрслэх урлаг, технологи	58	64	64	64	64	314
9	Хөгжим	58	64	64	64	32	282
10	Биеийн тамир	58	64	64	64	64	314
11	Эрүүл мэнд				32	32	64
12	Англи хэл					96	96
Багш зохицуулах цаг		58	32	32	32	32	186
Жилийн нийт цаг		727	736	736	800	896	3895
Долоо хоногийн нийт ачаалал		23	23	23	25	28	
Өдрийн дундаж ачаалал		4.5	4.6	4.6	5.0	5.6	

1. I-II анги 34 долоо хоног, III-V анги 35 долоо хоног хичээллэнэ.
2. Нэг ээлжит хичээлийн үргэлжлэх хугацаа I-II ангид 35 минут, III-V ангид 40 минут байна.
3. Нэгдүгээр ангийн суралцагч хичээлийн жилийн эхний 3 долоо хоногт бэлтгэл хөтөлбөрөөр хичээллэх бөгөөд өдөрт 4 цаг, долоо хоногт 20 цаг хичээллэнэ.
4. Багш зохицуулах цагийг хичээлийн цагт тооцно.
5. Багш зохицуулах цагаар суралцагчдын бие даан суралцах, багаар ажиллах чадвар, нийгэмшил, сэтгэл хөдлөлийн чадварыг хөгжүүлэхэд чиглэсэн интеграц хичээл, дугуйлан, төсөлт ажил, бүтээлч уншлагын цаг зэрэг үйл ажиллагааг хичээлийн жилийн туршид хэрэгжүүлнэ.
6. Хичээлийн жилийн хоёрдугаар улирлын сүүлийн 2 долоо хоногт төсөлт ажил, бие даалт, STEM сургалт зэрэг суралцагчдын асуудал шийдвэрлэх, бие даан суралцах, багаар ажиллах, нийгэмшил, сэтгэл хөдлөлийн чадварыг дэмжих, сурлагын хоцрогдол арилгахад чиглэсэн үйл ажиллагааг танхимын болон танхимын бус, хосолсон хэлбэрээр, багш нарын хамтын ажиллагаанд тулгуурлан арга зүйн цагийн хүрээнд хэрэгжүүлнэ.
7. Хичээлийн жилийн сүүлийн долоо хоногт III-V ангийн анги дэвших болон төгсөлтийн үнэлгээг зохион байгуулна.

## ДУНД АНГИЙН СУРГАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Анги		VI анги	VII анги	VIII анги	IX анги	Нийт цаг
1	Монгол хэл, бичиг	Монгол хэл	99	66	66	66	297
2		Үндэсний бичиг	66	66	66	66	264
3		Уран зохиол	66	66	66	66	264
4	Математик		165	132	132	132	561
5	Мэдээллийн технологи		33	33	33	33	132
6	Байгалийн ухаан	Физик	33	66	66	66	231
7		Биологи	33	66	66	66	231
8		Хими	33	66	66	66	231
9	Нийгмийн ухаан	Иргэний ёс зүйн боловсрол	66	66	66	66	264
10		Газар зүй		33	33	33	99
11		Түүх	33	66	66	66	231
12		Нийгэм судлал		33	33	33	99
13	Урлаг	Дүрслэх урлаг	33	33	33		99
14		Хөгжим	33	33	33	33	132
15	Дизайн технологи	Зураг зүй	66	66	66	66	264
		Технологи					
16	Биеийн тамир	Биеийн тамир	66	66	66	66	264
17	эрүүл мэнд	Эрүүл мэнд	33	33	33	33	132
18	Гадаад хэл	Англи хэл	99	99	99	99	396
19		Орос хэл		66	66	99	231
Дүн			957	1155	1155	1155	4422
Багш зохицуулах цаг			66	66	66	66	268
Жилийн нийт цаг			1023	1221	1221	1221	4690
Долоо хоногийн нийт ачаалал			31	35	35	35	
Өдрийн дундаж ачаалал			6.2	7.0	7.0	7.0	

- VI-IX анги 36 долоо хоног хичээллэнэ.
- Сургалтын төлөвлөгөөний заасан цагт багтаан орон нутаг, сургуулийн онцлогийг харгалзан ээлжит хичээлийг 40, эсвэл 80 минутаар зохион байгуулж болно.
- "Иргэний ёс зүйн боловсрол" хичээлийг нийгмийн ухааны багш заана.
- Багш зохицуулах цагийг хичээлийн цагт тооцно.
- Багш зохицуулах цагаар суралцагчдын бие даан суралцах, асуудал шийдвэрлэх болон нийгэмшил, сэтгэл хөдлөлийн чадварыг хөгжүүлэх, ажил мэргэжлийн чиг баримжаа олгоход чиглэсэн интеграц хичээл, дугуйлан, төсөлт ажил зэрэг үйл ажиллагааг хичээлийн жилийн туршид хэрэгжүүлнэ.
- Хичээлийн жилийн хоёрдугаар улирлын сүүлийн 2 долоо хоногт төсөлт ажил, бие даалт, STEM сургалт зэрэг суралцагчдын асуудал шийдвэрлэх, бие даан суралцах, багаар ажиллах, нийгэмшил, сэтгэл хөдлөлийн чадварыг дэмжих, сурлагын хоцрогдлыг арилгахад чиглэсэн үйл ажиллагааг танхимын болон танхимын бус, хосолсон хэлбэрээр, багш нарын хамтын ажиллагаанд тулгуурлан арга зүйн цагийн хүрээнд хэрэгжүүлнэ.
- Хичээлийн жилийн сүүлийн долоо хоногт анги дэвших болон төгсөлтийн үнэлгээг зохион байгуулна.

АХЛАХ АНГИЙН СУРГАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

Хичээл			Хичээлийн цаг (анги тус бүрээр)			Нийт цаг	
			X анги	XI анги	XII анги		
Заавал судлах	1	Монгол хэл	34	34	34	111	
	2	Үндэсний бичиг	68	68	68	222	
	3	Уран зохиол	34	34	34	111	
	4	Иргэний ёс зүйн боловсрол	68	68	68	222	
	5	Математик	102	102	102	333	
	6	Мэдээллийн технологи	34	34	34	111	
	7	Биологи	68	68		148	
	8	Физик	68	68		148	
	9	Хими	68	68		148	
	10	Монголын түүх	34	34		74	
	11	Нийгэм судлал	68	68		148	
	12	Газар зүй	68	68		148	
	13	Англи хэл/Орос хэл	102	102	102	333	
	14	Биеийн тамир	68	68	68	222	
	15	Эрүүл мэнд	34	34	34	111	
	16	Дизайн/зураг зүй, технологи	68	68	68	222	
Сонгон судлах	1	Хэл	Монгол хэл, бичиг	216	216	540	1107
	2		Уран зохиол				
	3		Англи хэл				
	4		Орос хэл				
	5	Математик	Математик				
	6	Байгалийн ухаан	Биологи				
	7		Физик				
	8		Хими				
	9	Нийгмийн ухаан	Нийгэм судлал				
	10		Түүх				
	11		Газар зүй				
	12		Бизнес судлал				
	13	Дизайн технологи	Дизайн, зураг зүй				
	14		Техник технологи				
	15		Мэдээллийн технологи				
Заавал судлах цаг			986	986	612	2584	
Сонгон судлах цаг			216	216	540	972	
Багш зохицуулах цаг			34	34	34	102	
Жилийн нийт цаг			1236	1236	1186	3658	
Долоо хоногийн нийт ачаалал			36	36	35		
Өдрийн дундаж ачаалал			7.3	7.3	7.0		

1. X-XII анги 37 долоо хоног хичээллэнэ.
2. Сургалтын төлөвлөгөөний заасан цагт багтаан орон нутаг, сургуулийн онцлогийг харгалзан ээлжит хичээлийг 40, эсвэл 80 минутаар зохион байгуулж болно.
3. Заавал судлах гадаад хэлний хичээлээр англи, орос хэлний аль нэгийг судална.
4. Суралцагч X ангид 4 хичээл, XI, XII анги тус бүрд 3 хичээлийг сонгон судална. Суралцагч X ангид хийсэн сонголтоо XI ангийн хичээлийн жилийн эхэнд нэг удаа өөрчлөх боломжтой. Харин XII ангид хичээл сонголтыг өөрчлөхгүй.
5. Сонгон судлах хичээл тус бүрийг X ангид 2 долоо хоногт 3 цагаар, XI ангид долоо хоногт 2 цагаар, XII ангид долоо хоногт 5 цагаар тус тус судална.
6. Заавал судлах хичээлийн цаг дээр сонгон судлах хичээлийн цагийг нэмж, заавал болон сонгон суралцах хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.
7. "Иргэний ёс зүйн боловсрол" хичээлийг нийгмийн ухааны багш заана.
8. Заавал болон сонгон судлах хичээлийг X, XI, XII ангийн сурагчдаас бүрдсэн холимог бүлгээр хичээллүүлж болно.
9. Багш зохицуулах цагаар суралцагчдын бие даан суралцах, асуудал шийдвэрлэх, нийгэмшил, сэтгэл хөдлөлийн чадварыг хөгжүүлэх, ажил мэргэжлийн чиг баримжаа олгоход чиглэсэн интеграц хичээл, дугуйлан, төсөлт ажил зэрэг үйл ажиллагааг хичээлийн жилийн туршид хэрэгжүүлнэ.
10. Хичээлийн жилийн хоёрдугаар улирлын сүүлийн 2 долоо хоногт төсөлт ажил, бие даалт, STEM сургалт зэрэг суралцагчдын асуудал шийдвэрлэх, бие даан суралцах, багаар ажиллах, нийгэмшил, сэтгэл хөдлөлийн чадварыг дэмжих, сурлагын хоцрогдлыг арилгахад чиглэсэн үйл ажиллагааг танхимын болон танхимын бус, хосолсон хэлбэрээр, багш нарын хамтын ажиллагаанд тулгуурлан арга зүйн цагийн хүрээнд хэрэгжүүлнэ.
11. Хичээлийн жилийн сүүлийн долоо хоногт анги дэвших болон төгсөлтийн үнэлгээг зохион байгуулна.